



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ**

2022 оны 05 сарын 19 өдөр

Дугаар 244

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгө акталж, данснаас  
хасах зөвшөөрөл олгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.4.5, 6.4.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Төрийн банкны харьяа Өвөрхангай, Өмнөговь аймаг дахь салбар банкны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн боловч дахин үнэлгээнд хамрагдсан, сэргээн засварлах боломжгүй болсон нь Мэргэжлийн хяналтын Улсын байцаагчийн 2022 оны 15/07/003/07, 2021 оны 16/07051/117 дугаар дүгнэлт актаар тогтоогдсон нийт 239,352,918.35 (хоёр зуун гучин есөн сая гурван зуун тавин хоёр мянга есөн зуун арван найман төгрөг гучин таван мөнгө) төгрөгийн балансын үнэ, 225,552,760.90 (хоёр зуун хорин таван сая таван зуун тавин хоёр мянга долоон зуун жаран төгрөг ерэн мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан барилга байгууламжийг цогцолбороор нь акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2.Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, Төрийн банкны гүйцэтгэх захирал Ө.Гантөр нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3.Акталж данснаас хассан барилгын доорх газрыг Төрийн банкны эзэмшилд хэвээр үлдээж, тус банкны барилга барихаас өөрөөр ашиглахгүй байх;

2.4.Арга хэмжээний биелэлтийг 2022 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТЭСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132002477

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2022 оны 05 дугаар сарын 29-ны өдрийн  
24/4 дугаар тогтоолын хавсралт



Төрийн банкны харьяа Өвөрхангай, Өмнөговь аймгийн салбар банкны  
үндсэн хөрөнгөд бүртгэлтэй ақталж, данснаас хасах хөрөнгийн жагсаалт

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад, бүртгэлд авсан огноо	Байршил	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэх өртөг (төгрөг)
1	Өвөрхангай аймгийн Бат- Өлзий сумын тооцооны төвийн байр /цогцолбороор/ /1 давхар, нийт талбай 80 м2/	2007/ 2007	Өвөрхангай аймаг, Бат-Өлзий сум, 4 дүгээр баг	28,894,320.00	26,482,200.15	2,412,119.85
2	Өмнөговь аймгийн Говьгурвансайхан тооцооны төв /цогцолбороор/ /2 давхар, нийт талбай 148 м2/	1956	Даланзадгад сум, 3 дугаар баг, Төв номын сангийн баруун талд	210,458,598.35	199,070,560.75	11,388,037.6
	<b>Нийт дүн</b>			<b>239,352,918.35</b> (хоёр зуун гучин есөн сая гурван зуун тавин хоёр мянга есөн зуун арван найман төгрөг гучин таван мөнгө)	<b>225,552,760.90</b> (хоёр зуун хорин таван сая таван зуун тавин хоёр мянга долоон зуун жаран төгрөг ерэн мөнгө)	<b>13,800,157.45</b> (арван гурван сая найман зуун мянга нэг зуун тавин долоон төгрөг дөчин таван мөнгө)